



ЦАГААННУУР СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.30 № СА-2020/04-НА-35
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагааннуур сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагааннуур сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020628

Дүгнэлт

Цагааннуур сумын Ардчилсан намын хорооны Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Цагааннуур сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр / 9 хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Цагааннуур сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

ЦАГААННУУР СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН 2020–2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЦАГААНУУР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

“Цагааннуурын хүний хөгжил, ерхийн өсөлт” гэсэн зорилтын хүрээнд иргэн бүр хүсэл мөрөөдөлтэй, хөгжих боломжийг дэмжсэн, иргэд нь хариуцлагатай, амьдралын зөв дадал хэвшилтэй ард иргэдийнхээ ая тухтай амьдрах бүхий л боломжийг бүрдүүлсэн тэргүүний сум байхын төлөө намын мөрийн хөтөлбөр боловсрууллаа.

1. Улс аймгийн бодлого зорилт, хөтөлбөрүүдийн хүрээнд тусгасан.
2. Сумын онцлог, тулгамдаж буй асуудлыг дэс дараатай тусгасан.
3. Сумын 1,2,3 дугаар багийн иргэдийн саналыг тусгасан.
4. Санхүү, хүний нөөцийн боломж бололцоог тооцож, боловсруулсан.
5. Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг тусгасан.
6. Үндэсний өв уламжлал, түүх соёл, ахмад настан хүүхэд залуучууд, ерх гэр бүлийн хөгжлийг дээдлэхэд чиглэсэн.
7. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”-д нийцсэн заалтуудыг тусгасан.
8. Хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, хариуцлагатай, ардчилсан Цагааннуур сумыг хөгжүүлэхийг “**Эрхэм зорилго**” болгосон.

НЭГ. ХҮН АМЫН ХӨГЖИЛ-НИЙГМИЙН БОДЛОГО

Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, сумынхаа түүх соёл уламжлалыг мэддэг өвөг дээдсийнхээ ёс заншлыг уламжлуулан авсан хөдөлмөрт дуртай, нутаг орон, хүн зоноороо бахархах дуртай, амьдралын зөв дадал хэвшилтэй боловсролтой иргэн болгон төлөвшүүлнэ.

1.1 Боловсролын салбарын хүрээнд

1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл, соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.1.2 Гадаадын их, дээд сургуульд жил бүр шилдэг сурагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх, хөрш зэргэлдээх улс орнуудтай боловсрол солилцооны чиглэлээр хамтарч ажиллана.

1.1.3 Хүүхэд залуучуудыг хөгжүүлэх “STEAM” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/

1.1.4 Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн тогтвортой, улс төрөөс хараат бус байх зарчмыг хэрэгжүүлнэ.

1.1.5 Багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, давтан сургах “Шинэ Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.6 Сум орон нутгийн эрэлтэд суурилсан хөдөө аж ахуйн мэргэжилтэн, агрономич, техникч, мал зүйч, аялал жуулчлал, маркетингийн мэргэжилтнийг бэлтгэх зорилгоор их, дээд сургуулиудтай хамтран ажиллана.



1.1.7 Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

1.2 Эрүүл мэндийн салбарын хүрээнд

1.2.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.2 Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.

1.2.3 Хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах, эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах бодлого баримтална.

1.2.4 Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.

1.2.5 Зөвшөөрөлгүй эмийн худалдаа эрхлэгчдэд тавих хяналтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

1.2.6 Сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгын санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

1.2.7 Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.3 Хүн амын өсөлт, хөгжил

1.3.1 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесийг хөгжүүлэх, амьдрах орчноо сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

1.3.2 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

1.3.3 Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжиж гэр бүл, нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлэх, өрх толгойлсон эх, эцэг, хагас болон бүтэн өнчин хүүхдийг эрсдэлээс хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

1.3.4 Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

1.4 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

1.4.1 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

1.4.2 Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, шаардлагатай ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн эдийн засгийн өсөлтийг бодлогоор дэмжинэ.

1.4.3. Сум хөгжүүлэх сангаас журамд нийцсэн зээл олгох, зээлийн эргэлтийг хурдасгах бодлого хэрэгжүүлнэ.

1.4.4 Орон нутагт гарааны бизнес шинээр эрхлэгчдэд зориулан төсөл, хөтөлбөр боловсруулж, хамтран ажиллана.

1.4.5 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлнэ.

1.4.6 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.4.7 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээ, үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.

1.4.8 Ахмадын сувилалд сумын ахмадуудыг хамруулах бодлого хэрэгжүүлнэ.

1.4.9 Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажил, үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

1.4.10 Иргэд, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.

1.5 Соёл урлагийн бодлогын хүрээнд

Сумын уламжлалт өв соёл, түүх, өвөг дээдсийн ёс заншлыг уламжлуулан авах, үе дамжсан тариаланчдын залгамж халааг нэмэгдүүлэх, зөв дадал төлөвшилтэй иргэн бэлтгэх бодлого баримтална.


1.5.1 Сумын соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлах, олны хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

1.5.2 Мэргэжлийн урлагийн байгууллага, залуу уран бүтээлчдийн уран бүтээлийг олны хүртээл болгох, ур чадвараа хөгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.

1.5.3 Сумын номын санг цахимжуулж, үйл ажиллагааг өргөтгөнө.

1.5.4 Хүүхэд, залуучууд чөлөөт цагаа өнгөрүүлэх, сургалтын төвийн зориулалттай барилга байгууламж, дэд бүтцийг бий болгох ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

1.5.5 Сумын спортын холбоодыг бодлогоор дэмжинэ.



1.5.6 Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, чөлөөт цагийн клубын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудыг дэмжинэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй

2.1.1 Газар тариалангийн аж ахуйн усжуулалтыг нэмэгдүүлэхэд газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.

2.1.2 “Атар-4” аяны хүрээнд хөрсний элэгдлийг багасгах, хөрс хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

2.1.3 Суманд 300 га ба түүнээс дээш хэмжээтэй газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийг ХАА-н чиглэлийн боловсон хүчнээр хангах бодлого хэрэгжүүлнэ.

2.1.4 Төмс, хүнсний ногооны тариалалтыг дэмжих зорилгоор “Хүлэмж, зoorь” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.5 Газар тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан газар эзэмших гэрээг жил бүр дүгнэж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ.

2.1.6 Нийт малын 60-аас дээш хувийг эрчимжсэн, өндөр ашиг шимтэй, таваарлаг болгоход малчдыг дэмжинэ.

2.1.7 Мах-нарийн ноосны чиглэлийн хангай, баяд үүлдрийн хонийг өсгөн үржүүлэхэд ХАА-н эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран ажиллана.

2.1.8 Үр тариа, төмс хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнүүдийн борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.1.9 Мал сүргийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах, өвс тэжээлийн хомсдолоос сэргийлж тэжээлийн нөөц бүрдүүлнэ.

2.1.10 Сүүний чиглэлийн монбилад, сементал, махны чиглэлийн ангус, лимузин үхрийг түлхүү үржүүлж, “Эрчимжсэн үхрийн аж ахуйн дэд хөтөлбөр”-ийг дэмжиж ажиллана.


2.1.11 “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.12 Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.1.13 Газрын үржил шимийг зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.1.14 Малыг тооноос илүү чанарт шилжүүлэх, бэлчээрийн даацыг тохируулах, хамгаалж, сайжруулсан иргэн, малчин өрхийг дэмжинэ.

2.2 Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлогын хүрээнд



2.2.1 Суманд нэгдсэн худалдааны төв \зах\-ийг байгуулах санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

2.2.2 Хөдөө аж ахуйн биржийн салбар байгуулах ажлыг дэмжинэ.

2.2.3 Мах, сүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

2.2.4 Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож, мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.

2.2.5 Суманд жуулчид хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.

2.2.6 Загас, загасан бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ нөөшлөх бичил бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.

2.2.7 Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтад тавих хяналтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

2.2.8 Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр орон нутгийн хэрэгцээг чанартай, хүртээмжтэй хангах, зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээг нэмэгдүүлэх бодлого баримталж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.

2.2.9 Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр гадаад, дотоодын орнуудын туршлагыг орон нутагтаа нутагшуулж, хэрэгжүүлнэ.

2.2.10 Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

2.3 Хөрөнгө оруулалт, дэд бүтэц, бүтээн байгуулалтын бодлогын хүрээнд

2.3.1 Сумын нийтийн эзэмшлийн зам, талбайн камержуулалтыг нэмэгдүүлнэ.

2.3.2 Шинэ суурьшлын бүс буюу 2, 3 дугаар багт инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг шинээр бий болгох санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

2.3.3 Сумын төв доторх 2.5 км авто замыг хатуу хучилттай болгох ажлыг эрчимжүүлнэ.

2.3.4 3 дугаар багт хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулна.

2.3.5 Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны өргөтгөлийн барилгын санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.



2.3.6 Ерөнхий боловсролын сургуулийн 210 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн байрны өргөтгөлийн санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

2.3.7 Сумын цахилгааны шугамын өргөтгөлийн санхүүжилтийг улс, аймгийн төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

2.3.8 Зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

2.3.9 Байгальд ээлтэй, ая тухтай амьдрах орчин нөхцөлтэй “Ногоон хөгжил”-д суурилсан эко жишиг гудамж бий болгох ажлыг хэрэгжүүлнэ.

2.3.10 Сумын ундны усыг цэвэршүүлэх, хүн амыг эрүүл ахуйн стандартад нийцсэн усаар хангах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.11 Сумын нэгдсэн хогийн цэгийг камержуулж, хашаажуулна.

2.3.12 Хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг хэвшүүлж, хэрэгжүүлнэ.

2.3.13 Айл өрхийн хаягжилтыг сайжруулна.

2.4 Төсөв санхүү, татварын бодлогын хүрээнд

2.4.1 Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүнг иргэд, олон нийтэд мэдээлэх, орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгыг иргэдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулна.

2.4.2 Татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

2.4.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.

2.4.4 Сумын статистик мэдээ, мэдээллийн бодит, үнэн зөв байдлыг дээшлүүлж иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

2.5 Байгаль орчны бодлогын хүрээнд:

2.5.1 Малчдын бэлчээр ашиглалтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.

2.5.2 Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллага болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна.

2.5.3 Ойн нөөцийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх мэргэжлийн байгууллагаар ойжуулалт хийлгэх ажлыг бодлогоор дэмжинэ.

2.5.4 Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлнэ.

ГУРАВ.ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН БОДЛОГО

4317143998
MHOA0065 905 2436

Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж, хяналт шинжилгээ үнэлгээний чанарыг сайжруулна.

3.1. Төрийн удирдлагын бодлогын хүрээнд

3.1.1 Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг өндөржүүлэх, албан хаагчдын манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх, албан хаагчдыг үнэлэх үнэлгээний аргачлалыг бий болгоно.

3.1.2 Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулж, мэргэшүүлнэ.

3.1.3 Сумын цахим хуудсыг шинэчлэн мэдээллийн баяжилтыг тогтмолжуулах, иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр шуурхай хангана.

3.1.4 Сум орон нутгийн цаг үеийн онцлог мэдээ мэдээллийг сурталчлах “Нуурын мэдээ” сониныг үргэлжлүүлэн улирал тутам гаргана.

3.1.5 Засаг даргын нэрэмжит үзлэгийг төр, төсвийн байгууллагуудад жил бүр зохион байгуулна.

3.1.6 Гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоог хангаж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.

3.1.7 Сумын гамшгаас хамгаалах штабын бэлэн байдлыг хангах, гамшиг ослын үед ажиллах хүн хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулна.

3.1.8 Цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулна.

3.2 Хууль эрх зүй, хүний эрхийг хангах бодлогын хүрээнд

Гэмт хэрэг, хүний эрхийн зөрчлийг арилган иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

3.2.1 Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж, захиргааны байгууллагуудаас иргэдийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.2 Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хүрээнд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлнэ.

3.2.3 Авлигын эсрэг хууль, журмын хэрэгжилтийг хангана.

3.2.4 Архивыг зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.5 Малын болон өмчийн хулгайтай тэмцэх ажлыг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд сумын төвд хөршийн холбоо, хөдөөд бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулна.

3.2.6 “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл”-ийн үйл ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

3.2.7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, хамгаалах ажлыг зохион байгуулна.

3.2.8 “Өсвөрийн цагдаа” бүлгийг ерөнхий боловсролын сургууль дээр ажиллуулах, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, гэмт хэрэг зөрчилгүй сургууль-анги хамт олон болох хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ.

3.2.9 “Архидалттай тэмцэх” хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн тоог бууруулах чиглэл баримтална.

3.2.10 2020-2024 онд гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.2.11 Гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.3.Дотоод гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд:

Дотоод, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн сайн туршлагыг орон нутагтаа нэвтрүүлнэ.


3.3.1 Ажил үйлсээрээ тэргүүний сум баг, байгууллагын ажлын туршлага судлах, танилцах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.3.2 Бүсийн хэмжээний сумдтай хамтран ажиллах, бүсийн зөвлөгөөн, уулзалт, үзэсгэлэн худалдаа, ажил мэргэжлийн туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулж, хамтран ажиллана.

3.3.3 Төрийн байгууллага, жижиг дунд үйлдвэр, газар тариалан, мал аж ахуйн салбарын хүрээнд сумын шеф байгууллага болон бусад аймаг, сумтай хамтран ажиллах, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулна.

3.3.4 ОХУ, БНХАУ, БНСУ болон бусад улс оронтой харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах, туршлага солилцох бодлого баримтална.

3.3.5 Нутгийн зөвлөл төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.



ЦАГААННУУР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

